

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны
03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**ХЭНТИЙ АЙМГИЙН УЦУОШТ-ийн УС СУДЛАЛЫН ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР БӨГӨӨД
УС, ЦАГ УУР ОРЧНЫ ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА АЛБАН ТУШААЛЫН
ТОДОРХОЙЛОЛТ**

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтын боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан.
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

**Холбогдох хууль тогтоомжийн нэр,
огноо:**

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21
өдрийн 240 дүгээр тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2024-10-01

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:**

Байгууллагын нэр:

Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны
шинжилгээний төв

Нэгжийн нэр:

Ус,Цаг уур орчны технологийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Ус судлалын технологич инженер бөгөөд
Ус, цаг уур орчны технологийн хэлтсийн
дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээний мэргэжил
ангилал, ТҮМ-7

Ажлын цаг:

Өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2-р баг
Тэмүүжингийн гудамж Н-13

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Онцгой нөхцлийн үед илүү цагаар
болон баяр амралт, шөнийн цагаар
ажиллана.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

- Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөрт ажлын биелэлт, хэмжлийн нэгдмэл байдал, ажиглалт, хэмжилтийн технологийг мөрдүүлж хэрэгжүүлэн, улсын сүлжээний салбар, нэгжийг өдөр тутмын мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж байгууллагын дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээг зохион байгуулах
- Гадаргын ус судлал /мөнх цас, цэвдэг/-ын шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөрийн хэрэгжилт, салбар, нэгжийн тасралтгүй, хэвийн ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдалд хяналт тавьж, хангах, ажиглалт, хэмжлийн технологийг мөрдүүлэх,

Албан тушаалын зорилт:

1. Монгол улсын хууль тогтоомж, Монгол улсын урт, богино, дунд хугацааны хөгжлийн бодлогын төлөвлөлт, Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай төрийн бодлого, төлөвлөлт, Засгийн газар, аймаг, орон нутгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах
2. Цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, ажиглалт, хэмжлийн чанарт хяналт тавьж, салбар, нэгжийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах, алдаа, зөрчил, үл тохирлыг арилгах, шалган туслах, мэргэжлийн арга зүйгээр хангах, дотоод аудит, хяналт үнэлгээ хийх
3. Цаг уур, орчны шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник, технологи, арга зүйн шинэчлэлийг нэвтрүүлэх, хяналт тавих, хөгжүүлэх, улам боловсронгуй болгох
4. Гадаргын ус судлал шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөрт хяналт тавьж, мэргэжил аргазүйн удирдлагаар хангах
5. Байгаль орчны шинжилгээний лабораторийн үйл ажиллагааг хянаж, стандарт, холбогдох хууль журмын биелэлтийг хангах
6. Улсын сүлжээний салбарын инженер, техникч нарын мэргэшлийн үр чадварыг сайжруулах, хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлтийг оновчтой зохион байгуулах
7. Ус, цаг уурын үйлчилгээний хөтөлбөрт ажлын биелэлтийг хангах, байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, судалгааны ажлыг удирдах
8. Хэлтсийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулалт, мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажиллах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	Монгол Улсын хууль, Засгийн газар, БОАЖЯ, ЦУОШГ-аас цаг уурын мэдээлэл, үйлчилгээний ажлын талаар гарсан тогтоол, тушаал, хөтөлбөр, удирдамж, журам, дүрэм, бусад байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг судлан хэрэгжилтийг зохион байгуулна.	Гүйцэтгэл хувиар	Г, Х, Ш,Т

	Дэлхийн цаг уурын байгууллага /ДЦУБ/-ын зөвлөмж, Монгол улсын ус, цаг уур орчны шинжилгээний ажлын хөтөлбөрийн биелэлтийг хангах, гүйцэтгэлийг нэгтгэн үнэлэх	Хэрэгжилт, хувиар	Г, Х, Ш,Т
	Засаг даргын мөрийн хөтөлбөр болон аймгийн дунд ба урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан ажил үүргийн биелэлтийг хангах	Хэрэгжилт, хувиар	Г, Х, Ш,Т
	Салбарын үйл ажиллагаатай холбоотой хугацаатай бичгийн хариу өгөх, гэрээ дүгнэх, тайлан мэдээг заасан хугацаанд явуулах, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах	Хэрэгжилт, хувиар	Г, Х, Ш,Т
2 дугаар зорилтын хүрээнд	ЦУОШГ-ын даргын 2016 оны а/02 тоот тушаалаар батласан шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах	Хөтөлбөрийн биелэлт, хувиар	Г.Х.Ш
	Улсын сүлжээний салбар нэгжүүдийн хөтөлбөрт тодотгол, өөрчлөлт хийх санал оруулах	Тухай бүр, гүйцэтгэлээр	Г.Х.Ш
	Улсын сүлжээний салбар нэгжүүдийг шинээр байгуулах, татан буулгах, түр нээх, түр хаах талаар судалгаа, дүгнэлт, үндэслэлийг гарган санал оруулах	Тухай бүр, гүйцэтгэлээр	Г.Х.Ш
	Улсын сүлжээний салбаруудын хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай хэмжих хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, хүснэгт, дэвтэр болон бусад материалын захиалгыг хүргүүлэх, салбаруудад хүргэх ажлыг зохион байгуулах	Боловсруулалтын чанар хувиар	Г,Х,Ш
	Хөтөлбөрт ажлыг тасралтгүй явуулах нөхцлийг хангахын тулд шаардагдах зардлын төсөл, саналыг байгууллагын удирдлагад хүргүүлж, шийдвэрлүүлэх	Хөтөлбөрт ажлын биелэлт хувиар	Г,Х,Ш,Т
	Жил бүрийн шалган туслах ажлын хөтөлбөр, хуваарийг гаргаж батлуулан биелэлтийг ханган ажиллах, шалган туслах ажлын үр дүнг байгууллагын удирдлага, даргын зөвлөлд танилцуулан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах	ШТА-ын төлөвлөгөөний биелэлт хувиар	Г,Ш,Т
	Байгууллагын хэмжээнд дотоод аудит хийх, төлөвлөгөө боловсруулж, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан, дүгнэлт, зөвлөмж сайжруулалтын ажлыг хийх.	Салбар нэгж, албан хаагчийн гүйцэтгэл сайжирсан байх	Г.Ш

3 дугаар зорилтын хүрээнд	“Хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах жилийн график, төлөвлөгөө”-ний биелэлтэнд хяналт тавих	Хэмжлийн гологдол гараагүй байх	Х.Ш
	Хэмжих хэрэгсэл, хэмжлийн технологид шинэчлэл хийх хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллах, хэрэгжилтийг зохион байгуулах.	Хэмжлийн алдаа, эргэлзээг багасгасан байх	Х.Ш
	Хэмжих хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах , хяналт тавих	Эвдрэл гэмтэл гараагүй байх	Г.Х.Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	Гадаргын ус судлалын шинжилгээний хөтөлбөрт хяналт тавьж, ус судлалын салбарын нэгжүүдийг мэргэжил аргагүйн удирдлагаар хангах	Салбарын ажлын дүн хувиар	Г,Х,Ш,
	Сарын УХШ-1 мэдээ, голын хэв, гажилтын зураглал хийж УЦУОСМХ -д дамжуулах	Материал боловсруулалт дүн хувиар	Г,Ш
	Сарын УД-1, УД-2 дэвтрийн боловсруулалтанд техник, шүүмж шалгалт хийж алдаа, үл тохирлыг арилгаж, давтан гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.	Ажиглалтын чанар хувиар	Г,Ш
	Нэгдсэн зураглал, хамаарлын муруйг сар бүрийн мэдээгээр уртасгаж хэмжпийн үр дүнд байнга хяналт тавих.	Хамаарлын муруйн дүн хувиар	Г,Ш
	Биологийн болон химийн шинжилгээний сорьцыг зааврын дагуу хугацаанд нь ирүүлэхэд хяналт тавих	Сорьцын дүн хувиар	Г,Ш
	Усны шуурхай мэдээнийн ирц, чанарт байнга хяналт тавих	Мэдээний дүн хувиар	Г,Ш
	Ус судлалын харуулын шалган туслах ажлыг жилд 2-оос доошгүй удаа хийх /репер, шон, хөндлөн огтлолын нивелердлэг хийж, репер, шонгийн засвар, үерийн түвшинг гарган хяналтын өнгөрөлт хэмжинэ, дэвтэр, хэмжих хэрэгсэл, технологи шалгах/.	Шалган туслах ажлын төлөвлөгөөний биелэлт, хувиар	Г,Ш
5 дугаар зорилтын хүрээнд	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтэнд хяналт тавьж заавар,зөвлөгөө өгөх	Салбарын үнэлгээ улсын дунджаж түвшнээс дээгүүр байх	Х.Ш
	Харилцагч байгуулагуудтай хамтран ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж, дүгнэх	Хуулийн дагуу гэрээ байгуулсан байх	Х.Ш
	БОШЛ-ыг итгэмжлэл,чанарын баталгаа, ур чадварын сорилтод хамруулах	Жил бүр “сайн”-аас дээш	Х.Ш

		үнэлгээтэй оролцох	
6 дугаар зорилтын хүрээнд	Инженер, техникч нарын мэргэшлийн ур чадварыг сайжруулах чиглэлээр сургалтын хөтөлбөр гарган ажиллах	Хөтөлбөрийн биелэлт хувиар	Г,Х,Ш
	Инженер, техникч нарын мэргэшлийн зэрэг хамгаалах, ахиулах ажлыг зохион байгуулах	Инженер, техникч нарын 90%-иас дээш хамрагдсан байх	Г.Х.Т
	Төрийн албаны болон харьяа салбаруудын сургалтад инженер, техникч нарыг хамруулах	Бүрэн хамруулсан байх	Х.Т
	Салбарын хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтыг хууль, дүрмийн дагуу явуулах	Хуулийн дагуу зөрчил, гомдолгүй явуулсан байх	Г.Х.Ш
7 дугаар зорилтын хүрээнд	Уур амьсгалын үйлчилгээний ажлын хөтөлбөрийн биелэлтийг хэрэгжүүлж ажиллах	Хөтөлбөрийн биелэлт 95%-иас дээш байх	Х.Ш
	Уур амьсгалын үйлчилгээ, судалгааны чиглэлээр ярилцлага, хэлэлцүүлэг, хурал зохион байгуулан нийтэд мэдээлэх	Жилд 1 –эс дээш удаа зохион байгуулсан байх	Г.Х.Ш
	Эрдэм, шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах	Инженер, техникч нарыг оролцуулсан байх	Г.Х.Ш
	Судалгаа, шинжилгээний үр дүн, цаг уурын бүтээгдэхүүн үйлчилгээг нийтэд түгээх ажилд заавар, зөвлөгөө өгч ажиллах	Байгууллагын цахим хаяг, мэдээллийн сувгаар мэдээлсэн байх	Х.Ш
	Уур амьсгалын үйлчилгээний төрөлжсөн ба нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж ашиглах.	Жил бүр баяжуулалтыг хийж байх	Х.Ш
8 дугаар зорилтын хүрээнд	Дээд байгууллага, удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж тайлагнах	Үүрэг даалгаврын биелэлт-100%	Г, Х,Ш
	Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөх хэрэгжүүлэх, хянах, биелэлтийг хангах	Зөв оновчтой төлөвлөлт хийсэн байх	Г, Х,Ш
	Хэлтсийн инженер техникийн ажилтан, улсын сүлжээний техникч нарын ажлын үр дүнг сар, жилээр дүгнэж урамшуулах, хариуцлага тооцох саналыг байгууллагын дарга, даргын зөвлөлд гарган шийдвэрлүүлнэ.	Хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэгдсэн байх	Г, Х,Ш
	Ажил үүргийн холбогдолтой гадаад, дотоодын төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах тухай гэрээ, хэлцэлийн төслийн бичиг баримтыг бүрдүүлэх	Журмын дагуу бүрэн боловсруулсан байх	Г.Т.Х
	Хэлтсийн албан хаагчдын хөдөлмөрийн	Ажиллах нөхцөл	Г.Х,Т,Ш

	нөхцөл, нийгмийн асуудалд анхаарч ажиллах	сайжирсан байх	
	Төрийн албан хаагчийн ёсзүй, үйлчилгээний стандартыг баримтлан, үлгэрлэн, манлайлж, мөрдөлтөнд өдөр тутам хяналт тавьж ажиллах	Салбарын ёс зүйн зөрчлийн тоо	Г.Х,Т,Ш

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Дээд боловсролын бакалавр түүнээс дээш магистр /доктор/	
Мэргэжил	Ус судлаач инженер D850200	
Мэргэшил	Цаг уур , Ус судлал, Орчны шинжилгээний чиглэлээр мэргэшиж, инженерийн зэрэг хамгаалсан байх	
Туршлага	УЦУОХШ-ний аль нэг салбарт 5-аас доошгүй жил тогтвортой ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> Байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулжг гүйцэтгэлийг үнэлэх Байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> Судалгааны дүнд тулгуурлан салбарын хөгжлийн зорилтыг тодорхойлох Тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> Хуульд нийцсэн шийдвэр гаргах Шийдвэрийн төслийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж шийдвэрийн хувилбарын талаар зөвлөх
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах Ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дууриал үзүүлэх
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> Албан хаагчдын санал бодлыг сонсож, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих Албан хаагч бүртэй тэгш хүртээмжтэй харилцах, ажиллах
	Бусад	<ul style="list-style-type: none"> Албан хэрэг хөтлөх, боловсруулах чадвартай байх Компьютерийн өргөн хэрэглээний болон салбарын үйл ажиллагаанд ашиглагддаг программ, технологиудыг ашигладаг байх Англи хэл эсвэл бусад гадаад хэлнээс мэргэжлийн дагуух эх сурвалж, мэдээллийг ашигладаг байх

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Ус цаг уур, орчны шинжилгээний Төвийн дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: - Салбарын технологич инженер -3 - Судалгаа үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн -3 - БОШЛ-ын эрхлэгч, ахлах шинжээч, шинжээч -3 - Багаж хэмжилзүйн техникч -1 - Өртөө хариуцсан инженер -8 - Цаг уурын техникч -50 Нийт -68	Бусад харилцах субъект: - ЦУОШГ-ын мэргэжилтэн - УЦУОСМХ-ийн мэргэжилтэн, инженерүүд - Орон нутгийн удирдлага, - Онцгой тохиолдолд бусад субъект

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<u>Албан тушаал:</u> (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2022 оны ... дугаар сарын ... -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u>

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u>	
<u>Шийдвэрийн огноо:</u>	
<u>Дугаар:</u>	
(тамга/тэмдэг) (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) оныдугаар сарын өдөр	

Танилцсан